



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/220

Сүхбаатар сум

Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Туузан метрээр хэмжилт хийгдэж олгогдсон Сүхбаатар сумын иргэн Боржигон овогт Бадарчийн Чинпүрэв /МЭ74120611/-д 2 дугаар баг Давчуу 2 дугаар гудамжны 202 тоотод байрлах гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалттай газрыг кадастрын зурагт орсон хэмжээ бүхий 4308011818 нэгж талбарын дугаартай 642 м² газрын эзэмших эрхийг баталгаажуулсугай.

2.Туузан метрээр хэмжилт хийгдэн анх олгогдсон дээрх газарт кадастрын зураглал хийн холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож эрхийг нь баталгаажуулан, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3.Эзэмшил газрынхаа арваас доошгүй хувьд ногоон байгууламж бүрдүүлэн, тохижуулж, хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг дээрх иргэн дүүрэг болгосугай.

4.Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д хариуцуулсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дээрх иргэний эзэмшилд олгосон Сүхбаатар хотын захирагчийн 1996 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 11 тоот шийдвэрийн холбогдох заалт, 60 дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээ, 001847 дугаартай гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/221

Сүхбаатар сум

Газар ашиглалтын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г" Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" 73 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2011 оны А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхийн ашиглалтын зориулалт өөрчлөх тухай хүсэлт гаргасан иргэн Түмт овогт Дашдоригийн Баасанжав /УС55072001/-ын Сүхбаатар сумын 4-р баг Буурын голын 1 дүгээр гудамжны 173 тоот хаягт байршилтай 4308С11762 нэгж талбарын дугаар бүхий 6799м² гэр бүлийн хэрэгцээний зориулалттай эзэмшил газрын эрхийн ашиглалтын зориулалтыг худалдаа үйлчилгээний зориулалттай болгон өөрчилсүгэй.

2.Дээрх газарт кадастрын зураглал хийн холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож эрхийг нь баталгаажуулан, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.

3.Эзэмшилд олгогдсон газраа тохижуулж хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг иргэн /Д.Баасанжав/-д үүрэг болгосугай.

4.Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ж.Отгонхүү)-д хариуцуулсугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/179 тоот захирамжийн иргэн Д.Баасанжавт холбогдох заалт, 000002801 дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээ, 2019/05910 дугаартай гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

